

## 2

## Ажлын байранд эрүүл мэндийг дэмжихэд суралцах, бусдад зааж сургах



Хүн бүр ажлын байран дээр нь эрүүл мэндэд хор хохирол учруулж буй зүйлсийн талаар мэдэж авах, ажлын байраа илүү эрүүл, аюулгүй болгохын тулд ямар арга замаар өөрчлөлт хийхээ тодорхойлоход суралцах боломжтой. Ийм ч учраас өөрчлөлт хийхдээ бусдыг татан оролцуулах, үүнд суралцахад нь нэг нэгэндээ тус болох явдал нэн шаардлагатай байдаг. Энэхүү номд эрүүл мэндийн ажилтан өөрийн үйлдвэрт хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа ашиглаж болох арга ажиллагааг тусгасан юм.

Номын тусламжтайгаар Та,

- Танай үйлдвэрт байгаа ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудлыг гаргаж ирэх,
- Танай үйлдвэрт гарч буй ажилчдын эрүүл мэндтэй холбоотой асуудлын шалтгааныг ойлгож мэдэх,
- Ажлын байран дээрх асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх арга замыг тодорхойлж, шийдэл олох,

- Ажлын байран дээрх асуудлыг шийдэх урт хугацааны ажлуудыг төлөвлөж, зохион байгуулах чадвартай болно.

## **Үйлдвэрийн ажил таны эрүүл мэндэд ямар аюул учруулдаг вэ**

Ихэнх үйлдвэрт ажилчдын эрүүл мэндэд аюул учруулах хүчин зүйл олон байдаг. Энэхүү номд орж буй “аюул” хэмээх үг нь үйлдвэрийн ажил танд (эсвэл хамт олонд) хор хөнөөл учруулж болох нөхцөл байдлыг илэрхийлж байгаа бөгөөд хэдийгээр бүх ажилчид гэмтэж бэртээгүй, осолд өртөөгүй, үүнийг мэдрээгүй байсан ч тэдний зарим нь цаашид ч өртөж болох тийм нөхцөл байдал юм. Эрүүл мэндэд нөлөөлөх асуудал нь (гэмтэл бэртэл, өвчлөл гэх мэт) ажилтанд шууд харагдаж, мэдрэгдэхгүй байж болох ч олон жилийн дараа, яваандаа илрэх боломжтой байдаг. Жишээ нь химийн бодис хэрэглэж ажилладаг ажилчдад тууралт илэрч болно. Химийн бодистой харьцаж ажилладаг өөр нэг ажилтан олон жилийн дараа хорт хавдраар өвчилж болно.

Ажлын байран дахь нөхцөл байдал, түүнтэй холбоотой асуудал нь шууд ил мэдэгдэхгүй тул, та ажлаа хийж дууссан л бол асуудал дууссан гэж бодож болохгүй. Тухайлбал, зарим химийн бодис нь хүний бэлгийн дур хүсэл, бэлгийн чадавх болон бэлгийн таашаал авах чадварыг бууруулах нөлөөтэй байдаг. Өөр нэг ноцтой зүйл бол хамт ажиллаж буй бүх хүнд яг ижил аюул заналхийлж байдаг. Жишээ нь баталгаагүй ундны ус эсвэл агаарын бохирдол гэх мэт.

Эрүүл мэндтэй холбоотой зарим асуудал “ажлын аюул”-аас шууд хамааралтай байдаг. Эдгээр асуудлыг зарим тохиолдолд амархан олж харж, шийдэж болдог. Ажлын аюулын зарим үзүүлэлтийг доор дурдвал,

- дахин дахин давтагддаг хөдөлгөөн;
- үйлдвэрт гарсан гал түймэр;
- химийн бодисын үйлчлэл;
- агааржуулалт тааруу байх;
- муудсан хүнсний бүтээгдэхүүн, баталгаагүй ундны ус, жорлон хүрэлцээгүй бөгөөд бохир байх, усанд орох боломжгүй байх зэрэг нөхцөл орно.

Ажлын байран дээрх зарим асуудлын шалтгаан нь үйлдвэрийн дотоод болон гадаад хүчин зүйлсээс улбаатай “нийгмийн аюул”-тай холбоотой байдаг. Нийгмийн зарим төрлийн аюулыг дурдвал,

- хэтэрхий бага цалин хөлс өгөх;

- нэгээс дээш долоо хоног дараалан шөнийн ээлжид ажиллуулах;
- үйлдвэрийн эзэн, бусад ажилчдын зүгээс дарамт шахалт үзүүлэх, мөрдөж мөшгөх болон айлган сүрдүүлэх;
- хэт олон цагаар амралтгүй ажиллуулах;
- хүйсээр ялгаварлах, язгуур угсаа, шашин шүтлэгээр гадуурхах, бэлгийн дарамт үзүүлэх;
- хэд хэдэн үүрэг даалгаврыг нэгэн зэрэг өгч гүйцэтгүүлэх зэрэг орно.


Бид ажлын байрандаа хувь хүнийхээ хувьд ажиллахад аюултай нөхцөл байдалд орж, нийгмийн аюулд өртөж байх юм бол дээрх асуудлыг ажилчдын эрүүл мэндийн асуудлаас ангид авч үзэх боломжгүйг харж байна. Эдгээр асуудал нь зөвхөн тухайн ажилчны хувьд төдийгүй түүнтэй хамт ажиллаж буй хүмүүсийн хувьд ч хортой нөлөө үзүүлж байдаг. Иймд эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтан болон ажилчид хамтдаа үүний эсрэг зогсож, асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах юм бол ажилчдыг гэмтээж, өвчлүүлэх шалтгааныг үүсгэж буй нөхцөл байдлыг үгүй болгох дорвитой өөрчлөлтийг хийж чадах билээ.

## **Ажилчдын эрүүл мэндийн асуудал олон шалтгаантай**

Ажилчдын эрүүл мэндийн асуудал нь олон шалтгааны улмаас үүсэн бий болдог. Асуудлыг ажиглаж, хэлэлцсэнээрээ шууд нөлөөлж буй зарим нэг шалтгааныг олж болох хэдий ч жинхэнэ шалтгааныг нь олохын тулд илүү гүн гүнзгий ухаж, олон зүйлийг нэмж тодруулах хэрэгтэй болох магадлалтай.

Үйлдвэрийн хаягдлаар бохирдсон гол далайд цутгаж байгаа тохиолдлыг жишээ болгон авч үзье. Та голын урсгалыг сөрж явахдаа хуванцар сав, лаазыг голд хаяж буй хүнтэй таарчээ. Магадгүй энэ хүн хүрээлэн буй орчны бохирдлын шалтгаан байж болох юм. Түүнд хог хаягдлыг бордоо болгон боловсруулах, хоёрдогч түүхий эд болгон хаягдлаа борлуулах аргыг зааж өгсний дараа хаягдал багассан ч гол урьдын адил бохирдсоор байв. Та урсгалыг сөрж дахин дээш яваад үзэхэд нэгэн гэр бүлийн угаадас болон жорлонгийн бохир гол руу орж байгааг харжээ. Магадгүй тэд орчныг бохирдуулж буй шалтгаан байж болох юм. Та тэдэнд бордоо гаргаж авдаг жорлон барихад нь тусалж, талбайг шүлтээр саармагжуулсны дараа хаягдал багассан ч гол бохирдсон хэвээр харагдана. Дээш өгсөн явахад хаягдлаа гол руу шууд урсган хаяж буй үйлдвэрийн газрыг олно. Хэрвээ тэд аюулгүй арга ажиллагаанд шилжиж, ойр орчимд нь амьдарч буй хөршүүд болон байгаль орчиндоо хүндэтгэлтэй хандаж, ажилчдынхаа эрүүл мэндэд анхаардаг болох юм бол хүрээлэн буй орчны бохирдол арилах болно.

Ажлын байран дээрх асуудал нь яг л энэ голын асуудалтай адил юм. Ажлын аюулын нэг шалтгаан нь хог хаяж буй хүн шиг хялбархан олж хараад өөрчилж болохоор байж болно. Тэглээ ч гэсэн та голыг өгсөн дахин явж, олж харахад бэрх шалтгааныг нь олж тодруулах хэрэгтэй. Бид ажлын байран дээрх асуудлыг шийдэхийн тулд нийгэм, улс төр, эдийн засгийн хүчин зүйл, түүний дотор компанийн хувьд хүнээсээ илүү, ашиг орлого олоход түлхүү анхаарснаас үүсэх эдийн засгийн хүчин зүйл, мөн арьс өнгөний үзэл, эмэгтэйчүүдийг хүйсээр ялгаварлан гадуурхах үзэл, хүчирхийлэл зэргээс үүдэлтэй нийгмийн асуудал, улс орныхоо засаглалын тогтолцоо болон удирдлагын арга барил, нийгмийн сэтгэлгээ зэрэг хүчин зүйлсийг ч нэгэн адил харгалзан үзэж шийдвэрлэх хэрэгтэй юм.



## Жуанитагийн түүх

Жуанита таван жилийн турш оёдлын машины оператораар ажиллаж байна. Үйлдвэрт ажиллахдаа түүний гар яг л цахилгаанд залгасан мэт түргэн хөдөлдөг бөгөөд өдөрт 800 удаа оёдол хийх тохиолдол нэг бус удаа тохиожээ. Тэрбээр оёдлоо хийхийн тулд оёж буй зүйлийнхээ зарим хэсгээс барьж, эргүүлж, түлхэж, татах бөгөөд үүний зэрэгцээ тоног төхөөрөмж болон контейнерийг холбох ажлыг гүйцэтгэдэг байв. Тэр долоо хоногт зургаан өдөр, өдөр бүр 10 цаг, заримдаа түүнээс ч илүү цагаар ажилладаг байлаа. Түүний ажлын хурд хангалттай их байсан ч удирдлагууд нь улам ихийг хийхийг шаарддаг байв.

Түүний мөр, гарын шуу нь хэдэн жилийн турш өвдөж байгаа ч, ажлаа хийж болоод байсан болохоор нэг их санаа зовсонгүй. Энэ өвдөлт ажлаас нь шалтгаалж байгааг тэр мэдэж байв. Баярын өдрүүдэд гэр бүлтэйгээ хамт байхаар ирэх үед нь өвдөлт намддаг байлаа. Өвдөлт яваандаа улам нэмэгдэж, тэр унтаж чадахаа болив. Түүний гар улам суларч, улам их янгинаж, ус зөөх, хоол хийх болон гэрийн бусад ажил хийхэд ч хүндрэлтэй байх болов.



Бусад ажилчид ч бас түүний нэгэн адил өвддөг болохыг тэр мэдэж байлаа. Бүгд л юу хийхээ мэдэхгүй, өвдөлт аяндаа намдах байх гэж найддаг байв. Тэр нэг удаа эмчид үзүүлье хэмээн зохион байгуулагчдаа хэлж үзсэн ч “Үгүй, ажилдаа буцаад ор” гэсэн хариу сонсжээ. Эцсийн эцэст, тэр ажлынхаа дараа эмчид үзүүлэхээр явсан байна. Эмч түүнд өвчин намдаах эм уугаад амрах хэрэгтэй хэмээн зөвлөжээ. Өөртөө эм худалдаж авах боломжгүй хэмээн бодсон ч эмийг авчээ. Уг эм нь хоёр сар орчим ажиллах боломж олгож, өвдөлтийг нь тухай бүр намдааж байв. Дараа нь улам их

өвдөж, ажиллах хурд нь буурснаар төлөвлөгөө нормоо биелүүлж чадахаа больсон тул ажлаасаа халагджээ.

Жуанита хэрхэн амь зуух аргаа мэдэхгүй байлаа. Түүнд оёдол хийхээс өөр хийж чадах ажил байсангүй. Тэр сургуульд ердөө хэдхэн жил сурсан бөгөөд гэр бүлд нь зөвхөн хөвгүүд л сургуульдаа суралцахаар үлдэж, бас өөр ажлын дадлага эзэмшдэг байлаа. Тэр гэр цэвэрлэж чадах ч энэ нь оёдол хийхээс хүнд, тэгээд ч энэ ажилд хэтэрхий бага цалин төлдөг байв. Удалгүй гар нь өвдөхөө больж оёдлын ажилдаа эргэн орно гэж найдах зам л түүнд үлджээ.

## Дасгал Гэвч яагаад?

Гэвч яагаад? асуултыг тавьснаар Жуанитагийн асуудлын шалтгааныг олж харах, шийдвэрлэх арга замыг сонгоход тусална.

“Гэвч яагаад” гэдэг асуултыг дахин дахин тавьснаар бүлгийн гишүүд Жуанитагийн түүхийг анх сонсож байснаасаа илүү ойлгож, олон шалтгааныг олж илрүүлэх боломж нээгдэнэ.

### 1. Яагаад Жуанитагийн гар тэгтлээ их өвдсөн бэ?

Түүний ажил нь хувцасны тодорхой хэсгүүдийг аль болох хурдан их хэмжээгээр оёхоор төлөвлөгдсөн. Жуанита бөхийж гараа байн байн эргүүлэн, нэг л үйлдлийг өдөрт хэдэн зуун удаа давтан хийх хэрэгтэй болсон байна.

### 2. Яагаад ажлын хуваарилалт ийм байгаа юм бэ?

Үйлдвэрийн эзэн үйлдвэрийг хурдтай, хямд үнээр ажиллуулдаг байлгахыг хүссэн юм. Үйлдвэрийн эзэн ажилчдын гар болон биед учирч болох ослоос хамгаалах талаар огт бодоогүй. Жуанитад ажилласан цагаар нь бус, харин оёсон хувцасны тоогоор нь бодож цалин өгдөг. Тиймээс Жуанита олон цагийн турш аль болох олон хувцас оёж байж амьдрах мөнгөө олдог байна.

### 3. Яагаад түүний цалинг хэдэн цамц оёсноор нь хэмжиж тооцдог вэ? Яагаад хэдэн цаг ажилласнаар нь цалинг тооцдоггүй вэ?

Үйлдвэрийн эзний хувьд бага хугацаанд олон цамц үйлдвэрлэх нь илүү

ашигтай. Үйлдвэрийн эзэн бусад үйлдвэрүүдтэй яг ижилхэн аргаар цалинг тооцдог.

**4.** Яагаад Жуанита ингэж их өвдөж байгаа хэр нь энэ ажлын байрандаа байсаар л байгаа вэ?

Энэ бол түүний хийж чадах цорын ганц ажил. Түүнд өөр сурсан зүйл, чадвар байхгүй. Түүний амьдардаг хотод бага сургууль төгссөн эмэгтэйчүүдийн ихэнх нь үйлдвэрт ажилладаг.

**5.** Яагаад энэ ажил Жуанитагийн хувьд олж болох хамгийн тохирсон ажил гэж?

Түүний гэр бүл маш ядуу учраас охидыг сургуульд явуулах талаар санаа тавиагүй. Үйлдвэрүүд ч бас Жуанита шиг ажилчдыг ажиллуулахыг боддог. Яагаад гэвэл тэд ажлаа алдахгүйн тулд тэр бүр гомдоллоод байдаггүй.

**6.** Яагаад үйлдвэрийн эзэн ажилчдаа бага цалингаар илүү цаг ажиллуулж байгаагаа хүлээн зөвшөөрөхөөс зайлсхийдэг вэ?

Засгийн газар нь хөдөлмөрийн хуулийг хэрэгжүүлдэггүй бөгөөд ажилчид үйлдвэрийн эзний эсрэг зогсох хүчгүй байдаг учраас тэр ажилчидтай өөрийн хүссэнээр харьцдаг. Олон хүн Жуанитагийн оронд ажиллахыг хүсэж байгаа нь тодорхой. Бусад оёдлын үйлдвэрийн ажилчид ч яг ижил нөхцөл байдалтай тулгардаг.

**7.** Яагаад Жуанита шиг ядуу хүмүүст илүү дээр нөхцөлтэй өөр ажлын байр олддоггүй вэ?


Ядуу буурай орнуудын олонх нь гадаадын компанийн хөрөнгө оруулалтыг татаж, Жуанита шиг хүмүүст ажлын байр бий болгож, үйлдвэр барихыг хүсдэг. Засгийн газар Экспортын бараа боловсруулах бүс байгуулж эсвэл эдгээр бизнест зориулж татварын хөнгөлөлттэй тусгай нөхцөл санал болгодог. Ингээд засгийн газар нь боловсрол, ажлын байрны сургалт болон Жуанита шиг хүмүүст илүү дээр нөхцөлтэй ажлын байр бий болгох хөтөлбөрүүдэд зарцуулах мөнгөө танадаг.

## Дасгал


**Ажилчдын эрүүл мэндийн асуудлын шалтгаанд дүгнэлт хийх**

Үйлдвэрийн ажилчдад тохиолдох янз бүрийн бэрхшээлийг шийдвэрлэх арга замын талаар болон дахин ийм асуудал тохиолдохоос хэрхэн зайлсхийх талаар ярилцана. Ажилчдын хувьд аль асуудал нь хамгийн чухал, аль асуудлыг нь тэд өөрсдөө өөрчилж чадах, өөр хэн бусад асуудлыг нь шийдвэрлэхэд тусалж чадах хамтрагч нь байж болох вэ гэдгийг ярилцаж болно. Ажилтан бүр өөр өөр асуулт асууж, харилцан адилгүй хариултыг сонсоно. Асуулт, хариултууд нь таны одоогийн нөхцөл байдлаас хамааран ялгаатай байх болно.

Бүлгийн гишүүд “Гэвч яагаад?” гэсэн асуултад хариулснаар Жуанитагийн тохиолдолд үүсээд байгаа асуудлыг олж харахад илүү хялбар болно. Жишээлбэл, “ажлын нөхцөл байдал, шалтгаан”, “нийгмийн нөхцөл байдал, шалтгаан”, “улс төрийн нөхцөл байдал, шалтгаан” гэх зэргээр бүлэг бүр ямар нэг нөхцөл байдлыг судлан, хуваагдан хэлэлцэж болно. Шалтгаан бүрээр өөрийн бүлгийг байгуулан ажиллаарай.




**Ажлын аюултай нөхцөл** гэдэгт химийн хор, гэмтэлтэй цахилгааны утас, шугам сүлжээ, өдөр бүр нэг үйлдлийг олон удаа давтан үйлдэх ажил болон шаардлага хангахгүй ундны ус зэрэг ордог.



**Нийгмийн шалтгаан** гэдэгт ажилчдын эрүүл мэндийн асуудалд хандах хандлага, уламжлал, үйлдвэрийн ажилчдын эрх ашиг болон нэр төрийг үл тоомсорлох үйлдлүүд, жишээ нь бага цалин, дарамт болон ялгаварлан гадуурхал зэрэг орно. Ялангуяа эмэгтэй ажилчид нь нийгмийн шалтгаант нөлөөнд их өртдөг.



**Улс төр, эдийн засгийн шалтгаан** гэж ямарваа газар нутаг, байгалийн баялгийг эзэмших, захиран зарцуулах эрх бүхий, тухайн хот, бүс нутаг болон улс оронд улс төрийн эрх мэдэлтний зүгээс гаргаж буй ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх үйлдлийг ойлгоно. Улс төр, эдийн засгийн шалтгаан гэдэгт үйлдвэрийн эзэд нь ажилчдыг олон цагаар ажиллуулаад өчүүхэн бага хөлс олгохыг дэмжсэн, нормоо биелүүлээгүй ажилтныг ажлаас халах явдлыг хүлээн зөвшөөрсөн хөдөлмөрийн хууль, улс төрийн бодлого болон үйлдвэрчний эвлэлийг хориглосон арга хэмжээг багтаадаг. Түүнчлэн аюулгүй ундны ус, ариун цэврийн үйлчилгээ, боловсролын болон бусад үйлчилгээг иргэдэд үзүүлдэггүй засгийн газар, мөн жижиг фермерүүд, малчид нь амь зуухын эрхээр хотод шилжин ирж ажил хайх, үйлдвэрт ажиллахаас өөр сонголтгүй байхыг албадсан бодлого, дарамт шахалтыг энэ ойлголтод багтаадаг байна.



## Асуудлыг шийдвэрлэж эхлэх арга замууд

Заримдаа асуудал юу болох нь тодорхой байгаа ч шийдэл нь юу байж болох талаар мэдлэг тааруу байдаг. Аюулгүй ажиллагааны болон эрүүл мэндийн мэргэжилтэн, эрүүл ахуйч, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын хөдөлмөр хамгаалал хариуцсан төлөөлөгчид болон бусад туршлагатай хүмүүсээс асууж шийдлээ олж болно. Ажилчид голдуу практик дээр үндэслэсэн туршлагаараа өөрсдийн ажлын байраа хэрхэн аюулгүй болгох талаар санаа оноо олсон байдаг. Мэргэжлийн хүрээний хүмүүсээс зөвлөгөө авснаар хамгийн үр дүнтэй, бодит байдалд ойр шийдлийг олж чадна.

**Богино хугацааны шийдэл:** Үйлдвэрийн эзнээс тусламж авах шаардлагагүй энгийн, өртөг багатай өөрчлөлтийг хийх нь асуудлаа шийдвэрлэж эхлэх сайн арга зам юм. Сайтар боловсруулсан богино хугацааны шийдэл нь ажилчдыг хамгаалаад зогсохгүй, цаашид урт хугацааны шийдлийг дэмжиж ажиллах боломжтой болгоно. Богино хугацааны шийдлийг хэрэгжүүлэх нь ажилчдыг бүх талаар хамгаалах ёстой үйлдвэрийн эзний үүргийг өөрчлөх ёсгүй. Гэхдээ ингэснээр ажилчид хариу үйлдэл хийх туршлага олж авч, илүү тохь тухтай ажиллах орчныг бий болгодог.

**Урт хугацааны шийдэл:** Эдгээрт аюул багатай химийн бодис хайх, агааржуулалтын шинэ систем, аюулгүй машин механизм, шинэ тоног төхөөрөмж авах, хамгаалалттай ажиллах процессыг нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагаа багтана. Багагүй хугацаа шаардаж зорилгодоо хүрэх эдгээр өөрчлөлтийг хэрхэн хийх талаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтнүүд загвар гарган өгч та бүхэнд туслах боломжтой. Энэ туслалцаа нь урт хугацааны



шийдлийг нэвтрүүлэхэд ажиллагчдыг татан оролцуулах ач холбогдолтой юм. Тэдний мэдлэг чадвар нь тоног төхөөрөмжийг загварчлах, суурилуулахад илүү зардал гаргахаас сэргийлээд зогсохгүй мэргэжилтнүүдийн зүгээс үзүүлэх шахалт нь ажлын байрны нөхцөлийг сайжруулах үйл явцыг илүү түргэсгэж чадна.

Үйлдвэрт гараад байгаа асуудлуудыг шийдвэрлэхээр ажилтнууд оролцож эхлэх үед та ч бас ажлын зохион байгуулалт, үр ашиг, үйлдвэрлэлийн чанар зэргийг сайжруулахад шинэ санаагаа нэмэрлэж болно. Асуудлыг шийдвэрлэх, шинэ санааг хэрэгжүүлэх эрх мэдэл нь хамт олны дунд эерэг өөрчлөлтийг авчирдаг.

## **Ажлын байранд эрүүл мэндийг дэмжихэд суралцахад нь ажилчдад туслах**

Ажилчид хамтран ажилласнаар ажиллах орчноо өөрчилж чадна гэдэгт итгэл дүүрэн байдаг хүмүүс бусад ажилчдадаа ажлын байранд эрүүл мэндийг дэмжихэд суралцах үйл явцад нь тусалж, энэ ажлыг зохион байгуулж чаддаг.

Ажлын байрандаа эрүүл мэндийг дэмжих талаар суралцаж, ажиллах орчноо илүү аюулгүй болгоход нь ажилчдад туслах, энэ ажлыг зохион байгуулах хүсэлтэй хэн нэгнийг “ажилчдын эрүүл мэндийн ухуулагч” гэж нэрлэж болно. Энэ хүн ажлын байрны орчин ажилчдын эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгааг бүрэн дүүрэн мэдэх албагүй. Ажлын байранд гарч байгаа бүх асуудал, ажилтан нэг бүрийн дэвшүүлсэн асуудлыг бүрэн дүүрэн шийдвэрлэж чадахгүй байж болно. Гэхдээ л ийм хүн байснаараа олон томоохон өөрчлөлтийг хийх боломжтой.

Ажилчдын эрүүл мэндийн ухуулагч нь хэн ч байж болно. Тухайлбал:

- ажилчдын хүндэтгэдэг, ярилцахыг хүсдэг хүн
- ажлын байран дахь эрүүл мэндийн асуудал нь бие махбодын болон нийгмийн нөхцөл байдлаас үүдэж буйг сайн мэддэг, туршлагатай хүн
- ажиллах нөхцөлийг хүмүүс бий болгодог тул ажилчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор дахин загварчилж болно гэдгийг мэддэг хүн
- эрх ашгаа хамгаалуулсан, эрүүл ажилчид нь илүү тогтвортой эрүүл бизнесийг бий болгож чадна гэдэгт итгэдэг хүн
- мэдээлэлтэй, сургалтад хамрагдсан, ажлын багажаа зөв эзэмшсэн ажилчид илүү сайн шийдвэр гаргаж, ажлын байраа эрүүл, аюулгүй болгож чадна гэдэгт итгэдэг нэгэн.

Ажилчдын эрүүл мэндийн ухуулагч нь голдуу сайн дурын ажилтан байдаг.



Хэрвээ үйлдвэрт үйлдвэрчний эвлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдлын хороо байдаг бол энэ ажилд оролцож болох юм. Ажилчдын эрүүл мэндийн ухуулагчийн өгөх гол амлалт нь ажилчдын ажиллах орчинг эрүүл, аюулгүй болгосноороо тэдний амьдралыг сайжруулах явдал юм.

Ажилчдын эрүүл мэндийн ухуулагчийн үүрэг:

- Ажилчдыг ажлын байрны эрүүл ахуйн тухай мэдээллээр хангаж, мэдлэгээ үйлдэл болгоход нь зөвлөх хангалттай мэдлэгтэй байх;
- Ажилчдад ажлын байранд анхаарах зүйл, хувийн асуудлаа зохицуулахад нь зааж туслах болон тэдний хувьд шийдвэрлэх шаардлагатай асуудлын талаар мэдээлэл цуглуулах;



**Ажлын байрны эрүүл ахуйн талаар хүн бүхэн суралцаж болно**

- ХАБЭА (хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй)-н ажилтнуудтай нөхөрсөг харилцаа тогтоон, өөрийн болон хамтран ажиллагчдын зүгээс гарч буй асуудалд туслалцаа авч, хариулгаа олж авах;

- Ажилчид ажлын байрандаа эрүүл мэндийг дэмжих оролцоонд дэмжлэг үзүүлснээр өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлэх. Ажилчид бол өөрсдийнхөө

хамгийн сайн өмгөөлөгч, тэд л ажлын байранд гарч байгаа асуудлыг өдөр тутам биеэрээ мэдэрч байдаг тул ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг сайжруулснаар ашиг тусыг нь хамгийн ихээр хүртэх хүмүүс юм;

- Өөрсдөд нь хамгийн их хамааралтай асуудлыг шийдвэрлэхээр хичээж байгаа ажилчдыг дэмжих.

## Мексикийн Ажилчдын эрүүл мэндийн ухуулагч бүсгүй

Мексикийн Эмэгтэй ажилчдын Фронт (CFO)-ын ажилчдын эрүүл мэндийн ухуулагч нар нь ажилчидтай ярилцаж, тэдэнд ажлын байрны нөхцөл байдлын тухай хоорондоо ярилцахад нь дэмжлэг үзүүлдэг юм. Ийм үйл явц аажмаар явагдах бөгөөд 3-4 хүн хоорондоо бухимдлаа хуваалцаж эхэлнэ. Энэхүү үйл явцын туршид ажилчид нь бүлгийн дотор өөртөө итгэх итгэлийг олж авна. Ихэвчлэн жижиг алхам хийж эхэлдэг ба удирдлагатайгаа зөрчилдөж байгаагаар дүрд орж тоглоно. Найзуудтайгаа дадлага хийсэн учраас ажилтан нь даргадаа үгээ хэлэх итгэлтэй болдог: “Та битгий над руу орилоод бай. Таныг зүгээр ярихад тань би хэвийн сонсоод ойлгож байна.” Дарга нар жижигхэн эсэргүүцэлд ч хүртэл гайхаж цочирддог бол ажилчид өөрсдийгөө хүчтэй юм байна гэдгийг мэдэж авдаг.



Бид өөрсдийн асуудлыг бусадтайгаа хуваалцаж, өөрсдийн эрхийн талаар мэдэж авахын тулд энэ байгууллагыг байгуулсан. Одоо бид ажил дээрээ санасан бодсон үгээ хэлж, удирдлагадаа хүргэж чадна.

## Ажилчдын эрүүл мэндийн ухуулагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлын зарчим

**1.** Ямар ч үйлдвэрийн хувьд хамгийн чухал зүйл нь ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал байдаг. Ажилчдын болон оршин суугчдын эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг сайжруулах зохион байгуулалт хийж үйлдвэрлэлээ загварчлах нь ажил олгогчийн нэн тэргүүнд хүлээх үүрэг хариуцлага юм. Харин үйлдвэрлэлийг шаардлагад нийцүүлэх, ашиг олох явдал хоёрдугаарт тавигдах учиртай.

**2.** Бүх ажилчид өөрсдийн харьцаж байгаа химийн бодис, материал, машин тоног төхөөрөмжийн талаар бүрэн мэдээлэлтэй байх эрхтэй. Химийн бодисын нэр төрөл, учруулж болох аюул, биеэ хамгаалах хэрэгцээний талаар ажилчдад мэдээлэл өгөх нь ажил олгогчийн үндсэн үүрэг юм.

**3.** Ажилчид аюултай нөхцөл байдал, аюултай эд зүйлстэй харьцаж ажиллахаас татгалзах эрхтэй.

**4.** Асуудлын уг үндсийг судлан, аюултай нөхцөл байдлыг засаж залруулан, илүү аюулгүй хувилбарыг нээж олох нь зөв алхам юм. Хамгийн сайн арга замыг олж аюултай эд зүйлийг аюул багатай зүйлээр сольж, ажиллах газар эсвэл машин техникт хамгаалалтын бүрхэвч хийх зэргээр машин механизмын аюултай байдлаас ажилчдыг хамгаалж, агааржуулалтыг сайжруулах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай. Бүр аргагүйдсэн үед л хөдөлмөр хамгааллын хувцсыг өмсөх юм уу, эсвэл нөөцөд ашиглаж болно.

Хөдөлмөрийн хуулийн дагуу бид аюултай орчинд ажиллахаас татгалзах эрхтэй.

Асууглаа шийдвэрлэхээс наам бид буцаж очиж ажиллахгүй.



**5.** Ажилчид нь ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөлийг хянаж, эрүүл мэндийн үйлчилгээ авах, үзлэг хяналтад хамрагдах эрхтэй. Ажлын байрны нөхцөл байдалд хяналт шинжилгээ хийх, ажилчдыг эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээнд үнэ төлбөргүйгээр хамруулах нь ажил олгогчийн үүрэг юм.

(үргэлжлэл)

**6.** Ажилчид болон тэдний ажиллаж байгаа байгууллага нь эрүүл, аюулгүй ажлын байрыг бий болгох хүчин чармайлт гаргаснаар ажиллах нөхцөл сайжирч, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэн, нийгмийн эрүүл мэндэд сайн нөлөө үзүүлдэг. Ажилчид нь чөлөөтэй зохион байгуулалтад орж ажиллахыг ажил олгогч дэмжих ёстой.

**7.** Эрүүл, аюулгүй ажлын байрны ашиг тусыг шууд хүртдэг хүмүүс нь ажилчид учраас тэд нөхцөл байдлыг сайжруулахад хамгийн хүчтэй, нөлөө бүхий хүчин болж чадна.

## Асуудалд дүгнэлт гаргаж, шийдвэрлэх алхам хийхэд нь ажилчдад дэмжлэг үзүүлэх


Хүний оюун ухаан бол өөрийн болоод найз нөхөд, эргэн тойрны хамтран ажиллагчид, гэр бүлдээ нөлөөлж нөхцөл байдлыг ойлгон өөрчлөлт хийх хамгийн шилдэг хэрэгсэл юм. Ажилчидтайгаа хамтран албан бус хэлэлцүүлэг өрнүүлэхдээ бусдыг дагах бус өөрсдөө бодохыг нь урамшуулах хэрэгтэй. Хүмүүсээс “Та юу гэж бодож байна?” хэмээн асуугаад хариулт бүрээс хамгийн хэрэгтэй, эерэг зүйлийг эрж ол. Хамгийн чанга дуутай хүнийг бус, харин хүн бүрийн үгийг сонсож байгаадаа итгэлтэй байхыг зорих хэрэгтэй. Хэн нэг нь асуудлын шалтгаан, үр дүнг эсэргүүцэх үед зүгээр л тоохгүй орхиж болохгүй, харин яг ямар асуудал гарав гэдгийг хайж ол. Эсрэг санал гэдэг бол бидэнд ажлын байран дахь асуудлыг өөр өнцгөөс олж харж, ярилцан шийдвэрлэж, илүү сайн ажлын байрыг бий болгоход туслах нэгэн боломж юм.

---

### Ажилчдын эрүүл мэндийн сайн ухуулагч дараах үйлдэлд шилжиж чаддаг. Үүнд:

Баримт нотолгоог хуваалцах шатнаас	→	ур чадварыг зааж сургах
Болсон явдлыг бусдад ярьж өгөх хэлбэрээс	→	асуудалд шийдэл олох
Анги танхимд ярилцах түвшнээс (онол)	→	үйлдвэр дээр хэрэгжүүлэх (практик)

---



2. Дүн шинжилгээ



1. Ажиглалт



3. Үйл ажиллагаа

## Ажилчдын эрүүл мэндийн ухуулагчдад өгөх зөвлөгөө

### Ажилчдын мэдэх зүйлээс яриагаа эхлэх

Төсөл, сургалт, хэлэлцүүлгийг хийхдээ хүмүүсийн мэдэж байгаа зүйлийг асууж, санаа зовж буй асуудлуудаа хуваалцах ярилцлагаар эхлэх хэрэгтэй. Хүмүүст туслахын тулд одоо тулгараад байгаа болон туулж буй ажлын нөхцөл байдлаа дүгнэж бодох боломж олгон, энэ нөхцөл байдал нь ирээдүйд эрүүл мэндэд нь ямар хор нөлөө үзүүлж болохыг ойлгуулах нь зүйтэй. Хуудас 64-65-д байгаа хүний биеийг зурах хичээл бол ажилчдын эрүүл мэндийн ухуулагч нь ажилчдын мэдлэгт тулгуурлан хэрхэн шинэ зүйл зааж өгөх тухай сайхан жишээ юм.

Тэрчлэн үйлдвэрт олон жил ажилласан туршлагатай хүмүүс хүртэл үйлдвэрийн ажиллах орчныг хэрхэн сайжруулах талаар хэзээ ч асууж байгаагүй байдаг. Үйлдвэрийн ажилчид бол ажлын нөхцөл байдлаа хэнээс ч илүү сайн мэддэг, илүү үр дүнтэй, сэтгэл хангалуун ажиллах орчинг бий болгоход шинэ санаа гаргаж чадах хүмүүс юм. Иймд ажилчдад өөрсдийн санаа бодлыг хэлэх, түүнийгээ хэлэлцэх боломжийг байнга олгох хэрэгтэй.

## Томоохон асуудлыг шийдвэрлэх

Эрүүл мэндэд хамгийн их сөрөг нөлөө үзүүлж байгаа асуудлыг эхлээд шийдвэрлэх гээд оролдож үзэх хэрэгтэй. Жишээлбэл, таны хувьд хамгийн чухал асуудал нь тодорхой хэмжээгээр химийн хортой нөлөөнд өртөхгүй байх явдал бол зарим хүмүүсийн хувьд илүү их цалин авах нь чухал гэж үзэж болно. Үүнээс гарах гарц нь цалингаа бууруулахгүйгээр хортой химийн бодистой ажиллах цагаа багасгах шийдэл байж болох юм. Мөн үүний хамтаар илүү аюул багатай химийн бодистой ажиллах, агааржуулалтыг сайжруулах шаардлага тавьж болно.

Хялбархан өөрчлөх, сайжруулах боломжтой асуудалд анхаарлаа хандуулснаар ажилчдын өөртөө итгэх итгэл, эрч хүчийг нэмэгдүүлж, илүү чухал өөрчлөлтийг хийх хүслийг нь өдөөж өгнө.

## Хамгийн чухал хэрэгцээтэй зүйлийг нь заах

Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны тухай маш их мэдээлэл байдаг. Гэвч бүх зүйлийг заана гэвэл цаг хугацаа их орно. Түүнээс гадна нэг дор хэт их мэдээлэл авбал, тус болохоосоо илүү хүмүүсийн толгойг эргүүлж орхидог.

“Яг ямар мэдээлэл манай ажлын байранд хамгийн их хэрэгцээтэй байна вэ?” гэж өөрөөсөө асуу. Хамгийн хэрэгцээтэй мэдээллээ өөрийн зааж буй хичээл, сургалтын цөм, хичээлийн агуулга болго. Ажилчдаар үйлдэл хийлгэж, өөрсдийн нөхцөл байдалд шүүмжлэлтэй хандахад нь тус болох арга хэрэгсэл, шинэ санаа өгөхийн зэрэгцээ бүтээлч сэтгэлгээндээ тулгуурлан асуудлын хариуг өөрсдөө бодож олж, шийдлийг нь гаргаж ирэхэд бэлтгэх тэдгээр мэдээлэлд нь гол анхаарлаа хандуул.



**Хамгийн чухал нь юу болохыг заах**

## Хүмүүсийн ойлгох үгийг хэрэглэх

Мэргэжилтнүүд гол төлөв шинжлэх ухааны нэр томьёо ашиглан ярьдаг. Тэд эдгээр техникийн нэр томьёо, хэллэгийг сургуульд сурах хугацаандаа сураад зогсохгүй зөвхөн зөв утгыг илэрхийлэх гэж ярихаас гадна мэдлэгтэй, байр суурьтай гэдгээ батлах гэж оролддог учраас ихэнх тохиолдолд мэргэжлийн нэр томьёогоор ярьдаг.

Гэтэл ихэнх хүмүүс техникийн хэллэгийг хэрэглэдэггүй, бас ойлгодоггүй. Харин ажилчдын эрүүл мэндийн ухуулагч та эдгээр мэргэжлийн нэр томьёог хүмүүсийн өдөр тутамдаа хэрэглэдэг үг рүү хөрвүүлэн орчуулж хичээлдээ ашиглаарай. Таны орчуулга төгс, “яг зөв” байх албагүй. Иймд хичээлд хамрагдаж байгаа ажилчдыг таны ярианд ойлгомжгүй үг хэллэг, мэдээлэл гарвал даруй зогсоож асууж байхыг эсвэл хэсэгчлэн тайлбарлах боломжтой гэдгийг тэдэнд байнга сануулж байгаарай.



## Хэрхэн суралцахыг заах

Хэн нэг нь ярьж, бусад нь зүгээр л сонсохоос илүүтэй өөрөө оролцож, ямар нэг зүйлийг хийх нь суралцах хамгийн сайн арга юм. Хичээлдээ сууж байгаа хүн бүрээс энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ гэдгийг асууж, аль болох тэднээр яриул. Дарга болон ажилчдын хооронд өрнөх (425 дугаар хуудсыг үзнэ үү) харилцан ярианы дүрд орж тоглох хөгжилтэй аргаар хүмүүсийг хичээлдээ оролцуулах нь дэмжиж болон эсрэг санал өгч байгаа шалтгаанаа тайлбарлан

ярихад хүргэж буй нэг жишээ юм.

Эрүүл мэндийн ухуулагч та шинэ санаа, мэдээллийг хуваалцахын зэрэгцээ хүмүүсийг өөрсдийн санаа бодлыг илэрхийлэхэд нь урамшуулах хэрэгтэй. Гэхдээ хамгийн гол нь мэдээллийг хэрхэн хайж олох, түүнийгээ ажилчидтайгаа хэлэлцэх, хэлэлцсэний үр дүнд хамтран ойлголцолд хүрэх талаар зааж өгөх нь чухал юм. Та энэ чадварыг тэдэнд эзэмшүүлснээр ажилчдын өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж, бие даан асуудал шийдвэрлэх чадварыг нь сайжруулж, санаачилгатай байдлыг нь дэмжихэд тусалж чадна.

## Танд тусламж хэрэгтэй үед

Ажлын байрны нөхцөл аюултай, үйлдвэрийн удирдлага илэрхий хууль бус үйлдэл хийж байгаа, та болон тантай хамтран ажиллагчид асуудлаа өөрсдөө шийдвэрлэх, ажлаа эвтэйхэн зогсоох боломжгүй мэт санагдаж болох юм.

Ийм тохиолдолд, өөрийн орны хуульд зааснаар та Хөдөлмөрийн яамтайгаа холбогдох, Галын хэлтэстэй холбоо тогтоох эсвэл Засгийн газрын бусад агентлагууд нь ажил олгогчийн асуудлыг шийдвэрлэх, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартыг мөрдөх, ажлын нөхцөл, цалин хөлс, урамшууллыг сайжруулахыг шаардах талаас нь нөлөөлөх боломжтой байдаг.

## Ажлын байрны хяналт шалгалтын эрх



**Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын конвенцын 81-р зүйлд** Засгийн газар нь хөдөлмөрийн хяналт шалгалтыг хуулийн хүрээнд бий болгох үүрэгтэй хэмээн заажээ.

Хяналтын байцаагч нь эмэгтэй, эрэгтэй аль ч хүйсийн хүн байж болох ба дараах эрх мэдлийг эдэлнэ. Үүнд:

- Урьдчилан хэлж сануулалгүйгээр ажлын байранд нэвтрэх, ялангуяа хууль зөрчигдөж байна гэж үзвэл;
- Ажилчидтай ярилцах;
- Ажилтай холбоотой аливаа бичиг баримттай танилцах;
- Хууль, дүрмийн талаар ажлын байранд мэдэгдэл байрлуулах;
- Материал, эд зүйлсээс шинжилгээнд өгөхөөр дээж авах;
- Хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай үр дүн гарах хүртэл ажлын байранд дахин дахин нарийвчилсан үзлэг хийх.

## Ажлын байрны хяналт шалгалтын эрх (үргэлжлэл)



**Мөн түүнчлэн хөдөлмөрийн хяналтын Конвенцод** хяналтын байцаагч бол доор дурдсан хөдөлмөрийн хяналтын системийн салшгүй хэсэг нь байх ёстой гэж заасан. Үүнд:

- Засгийн газарт ажлаа тайлагнах;
- Ажлын цаг, цалин хөлс, хөдөлмөр хамгаалал, эрүүл мэнд, хүүхдийн хөдөлмөр болон бусад асуудлаар хууль, дүрмийг мөрдүүлэн ажиллуулах;
- Ажилчид болон ажил олгогчдод техникийн мэдээлэл, зөвлөгөөг санал болгох;
- Одоо мөрдөж байгаа хуульд заагаагүй байсан ч зөрчилтэй асуудлыг Засгийн газарт илтгэх.

Нэгдсэн Үндэстний Байгууллага, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага болон бусад олон улсын байгууллагаас ажилчдын эрхийг ханган дэмжих талаар хүлээсэн үүргийг Хавсралт А-д тайлбарласан болно.

## Мэдээлэл, дэмжлэгийг хаанаас олох вэ

Ажлын байрны аюултай нөхцөл байдлын талаар болон уг асуудлын шийдлийн талаар мэдээлэл цуглуулах боломжтой олон эх сурвалж бий. ХАБЭА (хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй)-н дийлэнх ажилтнуудын хувьд ажилчдад туслах нь таалагддаг бөгөөд үүний тулд тэд ажилчдын ажилладаг хэсэгт очдог. Тэднээс тусламж хүсэхээс бүү санаа зов. Заримдаа хэдхэн энгийн асуултад хариулсан хэн нэгэн үйл ажиллагааг шинэлэг аргаар зохион байгуулахад тань туслах хамтрагч болох тохиолдол ч бий.



**Таны хамтран ажиллагчид** бол ажлын байрны нөхцөл байдлын талаар мэдээлэл авч болох шилдэг эх сурвалж төдийгүй тэрхүү нөхцөл байдлыг сайжруулах бодит санааг олох хамгийн боломжтой хүмүүс юм. Ажилчидтай байнга шинэ санаа, мэдлэгээ хуваалцаж ярилцах хэрэгтэй. Зөвхөн таньдаг мэддэг хүмүүстэйгээ ярилцахаас аль болох зайлсхий. Долоо хоног бүр шинэ хүмүүстэй ярилцахыг зуршил болгоорой.



**Үйлдвэрчний эвлэл** нь ихэнхдээ үйлдвэрийн ажилчдын эрүүл мэнд, эрхийн талаар мэдээлэл сайтай байдаг. Гишүүд нь ажилладаг үйлдвэрүүдийн аюултай нөхцөлийн тухай тусгайлсан мэдээлэл Үйлдвэрчний эвлэлд бий. Түүнчлэн Үйлдвэрчний эвлэл нь ажлын байрны асуудлыг шийдвэрлэх, ажилчдыг зохион байгуулах, гэрээний дагуу хэлэлцээр хийх, ажил олгогчоос гэрээнд өөрчлөлт оруулахыг шаардах талаар илүү их туршлагатай байдаг. Тэдний энэ туршлагаас суралцсанаар та юуг хийх, юунаас зайлсхийх талаар олон шинэ санааг олж авна.

**Олон нийтийн байгууллага** нь хууль, хүний эрх, олон нийтийн боловсролын стратеги, үйл ажиллагаа зохион байгуулах болон орон нутгийн улс төрийн нөхцөл байдлын талаарх мэдээллийн эх сурвалжтай байдгаараа ихээхэн тус болох боломжтой. Эмэгтэйчүүдийн, шашны, улс төрийн байгууллагууд нь үе үе эмэгтэйчүүдийн эрх, эрүүл мэндийн талаар идэвхтэй кампанит ажил явуулдаг. Зарим байгууллага үндэсний хэмжээний эсвэл олон улсын холбоо сүлжээгээрээ дамжуулан кампанит ажил явуулахад хэрэгцээтэй мэдээллийг цуглуулж түгээхэд тань туслах боломжтой.




**Засгийн газрын агентлаг** нь салбарт гарч болзошгүй аюултай байдлын тухай болон ажилтны эрх, эрүүл мэндийг хамгаалах хууль, дүрэм журмын талаарх мэдээллээр хангаж чаддаг. Тэд танд ажлын нөхцөл байдал хууль зөрчиж байгаа бол хэрхэн өргөдөл гаргах, хууль хэрхэн хэрэгждэг талаар хэлж өгч чадна. Засгийн газраас мэдээлэл хүсэхээр явахын өмнө тухайн албан тушаалтан болон агентлагт танд туслах хэмжээний эрх мэдэл, улс төрийн дэмжлэг байгаа эсэхийг нягтлаарай.



### **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн**




**мэргэжилтнүүд** нь ажлын үед гарч болзошгүй аюул болон эдгээрээс сэргийлэх арга, зарим шийдлийн талаарх техникийн мэдээллээр хангаж чадна. Мэргэжилтнүүд нь танай ажил олгогч аюултай асуудлыг шийдвэрлэхийн тулд хаанаас ямар сэлбэг, техник хэрэгсэл авч болохыг хэлж өгч чадна. Мөн тэдгээр мэргэжилтнүүдэд ажлын байрны аюултай нөхцөлийн хэм хэмжээг тогтоох багаж бий. Ажлын байранд дагаж мөрдөх ёстой хууль, дүрмийн талаар тэд сайн мэддэг. Тэд номоос, интернэтээс болон бусад мэргэжилтнүүдээс илүү их мэдээлэл олж авахад тань тусалж чадна.




**Компанийн бүртгэлд** янз бүрийн сэдвээр хэрэгцээтэй мэдээллийг төрөлжүүлсэн байдаг. Үүнд: ажлын цаг болон олгосон цалингийн тухай баримт, мэргэжлээс шалтгаалсан осол болон өвчлөлд өртсөн ажилчдын ажлын байран дээрх туршлага, компанийн орлого, зарлага, ямар төрлийн химийн бодис хэрэглэдэг болон ажлын байран дахь эрүүл мэндэд аюултай нөхцөл байдлын талаарх дүгнэлт гэх мэт. Зарим улс оронд ажилтан шаардсан тохиолдолд эдгээр мэдээллийг хүссэнээр нь гаргаж өгөхийг хуульчилж өгсөн байдаг.

**Ажил олгогчийн түүх** нь ажил олгогч тал ажилтнуудаа хангалттай хэмжээнд хамгаалаагүйгээс, аль эсвэл гал гарсан, химийн бодис асгарснаас үүдэн ажилчдад хохирол учирсан талаарх мэдээллийг агуулдаг. Магадгүй ажил



олгогч, үйлдвэрийн менежерүүд нь нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа өрнүүлсэн эсвэл орон нутгийн албан тушаалтнуудтай холбоотой болохыг олж мэдэх боломжтой. Та хуучин сонин, Засгийн газрын мэдээллийг шүүж болно. Одоо ажиллаж байгаа болон өмнө нь ажиллаж байсан ажилтнуудтай ярилцаад үзээрэй. Мөн уг байгууллагын талаарх олон нийтийн санаа бодлыг ч бас сонирх. Та хэнээс юу асуух, олохыг хүссэн мэдээллээ мэдэж авахын тулд хэрхэн асуух, тэдний өгсөн хариултад үндэслэн тухайн компанийн түүхийн талаар юуг ойлгож

авахаа урьдчилан бодож бэлтгэх нь зүйтэй. Нэг болсон үйл явдлын талаар хоёр хүн тэс өөр ойлголт өгч, үнэхээр хоёр өөрөөр тухайн болсон явдлыг өгүүлэх магадлалтайг анхаараарай.



**Ном ба интернэт** нь мэдээлэл авах томоохон эх сурвалж болдог. Эрүүл мэнд, хими, үйлдвэр болон бизнес гээд хайгаад үзээрэй. Та өөрийн улс орондоо мөрдөж байгаа хуулиар ажилчдын эрх, ажлын байрны эрүүл ахуй, эмэгтэйчүүдийн эрх зэрэг мэдээллийг төвөггүй олж чадна. Үүгээр зогсохгүй ажлын байрны эрүүл ахуйд хортой нөхцөлийн талаар нарийвчилсан болон илүү дэлгэрэнгүй мэдээлэл авч болох байгууллагуудын тухай мэдээллийг ч бас олж чадна.

## Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдэд өгөх зөвлөгөө

Бид бүгд үнэлэгдэхүйц хэмжээний мэдлэг туршлагатай ч, хэн маань ч “бүхнийг мэддэг” төгс нэгэн биш. Мэргэжилтнүүд ч нэгэн адил. ХАБЭА-н мэргэжилтний хувьд та мэдэж байгаа зүйлээ ажилчдад хэлж өгч, тэд хоорондоо ярилцан, байгаа мэдээлэлдээ шүүмжлэлтэй хандаж тунгаахад нь тусалж болно. Хэрвээ ажил олгогч болон мэргэжилтнээс өгч буй мэдээлэл нь ажилчдын амьдрал дээрх туршлагатай нийцэхгүй, нэг л буруу зөрүү санагдаад байгаа бол ажилчид өөрсдийн эргэлзээг тайлах явдлыг нь урамшуулан, боломжтой бол тэднийг илүү их зүйлийг бие дааж судлан мэдээлэл олж авах талаас нь дэмжих хэрэгтэй. Хэрвээ тэдний буруу байвал та олсон мэдээлэлд нь дүн шинжилгээ хийлгэж, тэднийг санаа бодлоо өөрчлөхөд нь туслах хэрэгтэй.



**Ажилчдыг алхам бүрт оролцуул.**

**Эхлээд ажилчидтай ярилцах.** Юуны түрүүнд ажилчдын туршлагыг асууж мэд. Үйлдвэрийн талаарх ном болон статистикийн төсөөлөл нь бодит байдал дээр ямар байв гэдэгт анхаарлаа хандуулж, тоо баримтыг тэмдэглэж ав.

**Ажилчид болон нийгмийн хувьд аль нь хамгийн чухал вэ гэдэгт анхаарах.** Магадгүй хамгийн хямд, хурдтай нь эсвэл ашигтай нь, аль эсвэл ажил олгогч юм уу, улстөрчийн ашиг сонирхол, амбицад сайн үйлчилдэг зүйл ч байж болно.

**Нийгмийн асуудалд анхаарал хандуулах.** Ажлын байрны дарамт болон цалингийн хэмжээ гэх мэт. Мөн эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын асуудал ч багтана. Ажлын байрны эрүүл ахуй нь зөвхөн машин техник, тоног төхөөрөмжөөс хамаардаггүй.

**Ялгаварлал, доромжлол зэргийн талаар ярихдаа илэн далангүй байх.** Үйлдвэрчний эвлэлийн төлөө ажилладаг зарим нэг ХАБЭА-н мэргэжилтнүүдэд хүмүүс тэр бүр итгэдэггүй. Бүр олонд танигдсан, байгууллагын албан ёсны болон засгийн газрын үйлдвэрчний эвлэл байсан ч гэсэн итгэдэггүй.

**Мэдлэгээ хуваалцах.** Ажилчидтай мэдлэгээ хуваалцсанаар та тэднийг ажлын байрныхаа эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар санаа тавьдаг хүмүүс болгож чадна.